

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-2
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	3-6

---

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаа болон батлагдсан хууль тогтоомжуудыг судлан шалгах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай/	3-6
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
12 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 56.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Энхтуяа;  
Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ц.Даваасүрэн, Д.Жаргалсайхан, Г.Очирбат,  
Б.Пунсалмаа, Б.Тулга;  
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Пүрэвдаваа;  
Тасалсан: С.Лүндэг.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаа болон батлагдсан хууль тогтоомжуудыг судлан шалгах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны референт Г.Баярмаа байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Д.Батлут, С.Замира, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

**С.Ганбаатар:** “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаа болон батлагдсан хууль тогтоомжуудыг судлан шалгах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 2  
Бүгд: 14  
85.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 14 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 92.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаа болон батлагдсан хууль тогтоомжуудыг судлан шалгах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, Б.Пунсалмаа, Г.Очирбат, С.Замира, Ж.Золжаргал нар ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 08 минут үргэлжилж, 23 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 60.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 32 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим 18 цаг 24 минут.

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН**  
**ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Ганбаатар:** Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан эхлэхэд бараг бэлэн болж байна. 1 гишүүн үү, ирц 43,5 хувьтай явж байна. Ирцээ танилцуулах уу.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан эхэлж байна.

Ирцийг та бүхэндээ танилцуулъя. Ирц 56,5 хувьтайгаар хурлаа эхлүүлэе. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Хажекберийн Жангабыл гишүүн ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Сонгобайгийн Замира гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд ирц 56,5 хувьтайгаар хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаа болон батлагдсан хууль тогтоомжуудыг судлан шалгах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг байгуулахаар ийм хэлэлцэх асуудал орж ирж байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудлын 1.

**“Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн дагуу байгуулагдсан паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай

хуулийн хэрэгжилт болон Үйлдвэр технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлын явц, цаашид шийдвэрлэх асуудлын талаарх мэдээллийн сонссонтой холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулахаар тогтоосны дагуу тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд тараасан байгаа.

Ингээд тогтоолын төслийг та бүхэнд бас уншиж танилцуулах ёстой.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйлдвэр технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын үйл ажлын явц, цаашид шийдвэрлэх асуудлын талаарх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцсэнтэй холбогдуулан хууль тогтоомжийн хэрэгжилт болон үйлдвэр технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Уянга Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Д.Батлут Улсын Их Хурлын гишүүн, Д.Батбаяр Улсын Их Хурлын гишүүн, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, Б.Пунсалмаа, Д.Батлут дээр орчихсон байна шүү. Улсын Их Хурлын гишүүд.

2. Ажлын хэсгийн тайлан, холбогдох санал, дүгнэлтээ 2025 оны хаврын чуулганы хуралдаанд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Б.Уянгаад даалгасугай.

3. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор холбогдох байгууллагаас эрх бүхий албан тушаалтныг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Б.Уянга, ажлын хэсэгт зохион байгуулалтын талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны С.Ганбаатарт даалгасугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоол байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Золжаргал гишүүн байгаа юм байна. Ингээд Замира гишүүнээр тасаллаа. Золжаргал гишүүнээр тасаллаа.

Очирбат гишүүний микрофоныг нээж өгье.

**Г.Очирбат:** Бас ажлын хэсэгт орж ажиллах сонирхолтой байгаа. Тэгэхээр нэрийг маань нэмж өгнө үү.

**С.Ганбаатар:** Батлут гишүүний микрофоныг нээж өгье. Үг хэлнэ үү. Асуулт асууна уу.

**Д.Батлут:** Тогтоолын төсөлтэй танилцлаа. Энэ Байнгын хорооны хурлын асуудлууд протоколоор явж байгаа учраас таны хэлж байгаа зүйл, тогтоолын төсөл 2 жоохон зөрөөд байгаа. Үүнийг нэгтгэх ёстой гэж харж байгаа. Магадгүй энэ тогтоолын төсөл дээр та урьд нь танилцуулахдаа хянан шалгах гэж үг оруулаад байгаа. Тэгэхээр тогтоолын төсөл дээр тийм үг байхгүй байна.

Тэгэхээр энэ 2-ын аль нь юм бэ гэдгийг чиглэл болгоод тодорхой болгочих нь зүйтэй. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Яг зөв асуулт асууж байна шүү. Би бас ажиглаж байсан, тийм. Тэрийг тодруулна.

Замира гишүүн асуулт асууя.

**С.Замира:** Оройн мэнд хүргэе. Энэ ажлын хэсэг дээр би байсан. Тэгэхдээ нэр байхгүй болчих юм. Нэрээ оруулж өгнө үү гэж. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Ойлголоо Замира гишүүн. Очирбат гишүүн.

Золжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Золжаргал:** Ажлын хэсэгт оролцох хүсэлтэй байна. Шийдвэрлэж өгнө үү.

**С.Ганбаатар:** Ингээд гишүүдийн асуултад би хариулъя.

Батлут гишүүн маш нарийн ажигласан байна. Би бас харж байсан. Яг нөгөө тогтоолын төсөл дотроо хяналтын гэж үг байхгүй байна лээ. Тэр чинь маш том эрх мэдэл бас өөр болоод явчихдаг юм шүү.

Тэгэхээр энэ бол хяналтынх шүү. Үүнийг протоколд тэмдэглүүлж, заслаа.

Тэгээд Очирбат гишүүн, Замира гишүүн, Золжаргал гишүүнийг, Пунсалмаа гишүүн, Батлут гишүүн орчихсон юм байна. Ингээд энэ гишүүдийг нэмээд ажлын хэсгийг байгууллаа.

Ингээд ажлын хэсэг энэ тогтоолын төслийг батлах саналтай байна. Санал хураалт. Хяналтын.

Санал хураалтыг цуцалъя.

Тийм, тийм, Батлут гишүүн ээ, сая таны саналыг хүлээж аваад, тогтоолын төсөл дээр хяналт шалгалтын гэж нэмж оруулаад баталъя гэж протоколд бүр тусгаж үг оруулж байгаа юм шүү.

Ингээд тогтоолын төслийг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Далайн Батбаяр гишүүн дэмжсэн, протоколд тэмдэглүүлье.

Ингээд 85,7 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдэж, батлагдлаа.

18.32 цаг

Ингээд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Уянга гишүүндээ ажлын өндөр амжилт хүсье. Улам амжилттай ажиллаарай.

Баярлалаа, та бүхэнд.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ